

**"БАГАНУУР" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

"Багануур" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 10:00 цагт Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13-р хороолол, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж, 23-01 тоотод байрлах "Багануур-Илч" ХХК-ийн 2 давхарт хурлын танхимд хуралдав.

ХУРЛЫН ИРЦ: Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг хувьцаа эзэмшигчдээс брокерын пүүсүүдээр дамжуулан хуралд оролцох санал ирээгүй, 20,147,438 ширхэг хувьцааг төлөөлж 4 хүн итгэмжлэлээр, 811 ширхэг хувьцаа эзэмшигч 6 хүн өөрийн биеэр нийт 20,148,249 хувьцаа эзэмшигч оролцож хурал 96,06 хувийн ирцтэй хуралдав.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛСАН

Д/д	Нэр	Албан тушаал
1	Д.Даваадаш	Хурал зохион байгуулах комиссын дарга, "Багануур" ХК-ийн Хүний хөгжил судалгаа эрхэлсэн дэд захирал
2	Б.Одгэрэл	"Багануур" ХК-ийн хуулийн зөвлөх
3	У.Батсуурь	"Багануур Илч" ХХК-ийн Гүйцэтгэх захирал
4	С.Одончимэг	"Багануур" ХК-ийн Хэвлэл мэдээллийн ажилтан
5	Г.Соёлмаа	"Багануур" ХК-ийн Төлөөлөгчийн газрын менежер
6	Ч.Сайнзаяа	"Багануур" ХК-ийн Гүйцэтгэх захирлын туслах
7	А.Ганболор	"Багануур" ХК-ийн ажилтан
8	Б.Хажидмаа	Тооллогын комиссын дарга, "Багануур" ХК-ийн ДХША-ны дарга
9	Б.Наранцэцэг	Тооллогын комиссын гишүүн, "Багануур" ХК-ийн ДХША-ны мэргэжилтэн
10	М.Дондогдулам	Тооллогын комиссын гишүүн, "Багануур" ХК-ийн ДХША-ны мэргэжилтэн

ХУРАЛД ОРОЛЦСОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ:

1. С.Наранцогт Хувьцаа эзэмшигч "Эрдэнэс Монгол" ХХК
2. Б. Гэрлээ Хувьцаа эзэмшигч "Эрдэнэс Монгол" ХХК
3. Б.Батбаяр Хувьцаа эзэмшигч "Эрдэнэс Монгол" ХХК
4. М.Отгонбаяр- Хувьцаа эзэмшигч /Монголиан нейшнл коүл корпорейшн ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч/
5. С.Уранчимэг
6. С.Бямбасүрэн
7. О.Эрдэнэбилэг
8. Г.Бат-Эрдэнэ
9. Ж.Энхтунгалаг

ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛААР ТАНИЛЦУУЛСАН:

1. Д.Түвшинжаргал “Багануур” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч
2. Б.Наранбаатар “Багануур” ХК-ийн Ерөнхий нягтлан бодогч
3. Д.Даваадаш “Багануур” ХК-ийн хүний хөгжил судалгаа эрхэлсэн дэд захирал
4. Ч.Дондогмаа Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга
5. Б.Чойжил Төлөөлөн Удирдах зөвлөлийн аудитын хорооны дарга
6. Б.Мөнхзаяа Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүн

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Компанийн 2023 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай
2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
3. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
4. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гарсан Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн танилцуулга;
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Б.Хажидмаа /Тооллогын комиссын дарга/: “Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг танилцуулав. Хуралдааны ирц бүрдсэн тул хурлыг хуралдуулахыг зөвшөөрч байна.

Ч.Дондогмаа /Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга/: 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 07 дугаартай тогтоолыг уншиж танилцуулан өнөөдрийн хуралдааны даргалагчаар С.Наранцогтыг томилсныг танилцуулав.

С.Наранцогт /Хуралдаан даргалагч/: Хурлыг нээж хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулав. Нэгдүгээр асуудал болох Компанийн 2023 оны санхүүгийн тайлангийн танилцуулгыг Багануур ХК-ийн Ерөнхий нягтлан бодогч Б.Наранбаатар танилцуулна уу.

Б.Наранбаатар /Багануур ХК-ийн Ерөнхий нягтлан бодогч/: Компанийн 2023 оны санхүүгийн тайланг танилцуулав.

Үүнд: **Компанийн санхүүгийн ерөнхий мэдээллийн хүрээнд**: 2023 оны 12 сарын 31-ны байдлаар нийт хөрөнгийн хэмжээ 265,383.8 сая төгрөг болж өмнөх оноос 9,645.5 сая төгрөгөөр буюу 4 хувь нэмэгдсэн ба нийт өр төлбөрийн хэмжээ 242,920.5 сая төгрөг болж өмнөх оноос 72,318.6 сая төгрөгөөр буюу 42 хувь нэмэгдсэн байна. Эздийн өмчийн хувьд 22,563.3 сая төгрөг болж өмнөх оноос 11,673.1 сая төгрөгөөр буюу 34 хувиар багассан байна.

Аудитын тайлан. Хязгаарлалттай дүгнэлт гарсан.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзэж санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Багануур ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл: Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулаагүй дараах алдаа, зөрчил нь тогтоосон 1,610.7 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давж, санхүүгийн тайлагналд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Үүнд: Авлагын 3,005.3 сая, өглөгийн 989.3 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, 8 газар эзэмших эрхийн үнэлгээг хийгээгүй, нөөц өр төлбөр 1,167.0 сая төгрөг хэрхэн үүссэнийг нотлох баримт байхгүй зэрэг зөрчил илэрсэн.

Аудитын байгууллагаас өгсөн 9 албан шаардлага, 4 зөвлөмж.

Өмнөх аудитаар хүргүүлсэн дараа тайлангийн журамд заасан хугацаанд хаах 118.7 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй.

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын дагуу 9,407.0 сая төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулахаас 989.3 сая төгрөгийн 38 харилцагчийн өр төлбөр мөн 3,005.4 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.

5.0 сая төгрөгөөс дээших 478.1 сая төгрөгийн 23 удаагийн зарлагын гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй.

6 төсөл арга хэмжээний 1,949.5 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгаа гаргуулж аваагүй, 4 төсөл арга хэмжээний 6,167.4 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулснаас хойш авсан.

2021-2022 онд ажиллаж байсан ТУЗ-ын гишүүдэд олгосон жилийн үр дүнгийн урамшуулал 33.0 сая төгрөгийг барагдуулж, байгууллагыг хохиролгүй болгох.

Бараа материалын үлдэгдлийг тооцохгүйгээр худалдан авалт хийж, насжилт өндөртэй бараа материалын нөөц бий болсон.

Тайлангийн хугацаанд 75 харилцагчийн 1,550.7 сая төгрөгийн авлага, 25 харилцагчийн 535.8 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэл насжилт өндөр болсон, хугацаанд нь барагдуулах

8 газар эзэмших эрхийн үнэлгээг хийгээгүй, санхүүгийн тайланд тусгаагүй.

Хараат компани Монцахим ХХК-д оруулсан хөрөнгө, Монцахим ХХК-ийн бүртгэл дээрх хөрөнгө хоорондоо 93.5 сая төгрөгөөр зөрүүтэй.

Тендерийн бичиг баримтын бүрдүүлэлт хангалтгүй, гарын үсэг байхгүй, хурлын тэмдэглэлд гишүүдийн саналыг тодорхой тусгадаггүй.

Элэгдлээр анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийн дахин үнэлж бүртгэлд тусгах

Санхүүгийн тайлангийн нөөц өр төлбөр /урт хугацаат өр төлбөрт/ 1,167.0 сая төгрөгийн үлдэгдлийг тодруулах.

НӨАТ-ын орлого дутуу тайлагнасан, татварын өр төлбөр 46.3 сая төгрөгөөр зөрүүтэй.

Зөвлөмжийн дагуу хийх ажлууд.

Авлагын тооцоо нийлээгүй байгууллагуудтай тооцоо нийлэх, 2024 оны 3 дугаар улиралдаа авлагын тооцоо нийлэх ажлыг эрчимжүүлж ажиллана.

Өр төлбөртэй компаниудтай тооцоо нийлэх 2024 оны 3 дугаар улиралдаа өглөгийн тооцоо нийлэх ажлыг эрчимжүүлнэ, тооцоо нийлсний дараа өр төлбөрийг шилжүүлэх,

Хуралд танилцуулсан материалыг хавсаргав.

С.Наранцогт /Хуралдаан даргалагч/: Хувьцаа эзэмшигч нарт Компанийн 2023 оны санхүүгийн тайлантай холбоотой асуулт байна уу ?

Асуулт: М.Отгонбаяр /Монголиан нейшнл коул корпорейшн ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч/: Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө буюу эздийн өмч өмнөх оноос буурсан уу ? буурсан бол хэр их хэмжээгээр буурсан бэ ?

Хариулт: Б.Наранбаатар /Багануур ХК-ийн Ерөнхий нягтлан бодогч/: 2023 онд хувьцааны нэгж үнэд өөрчлөлт ороогүй хувьцааны нэгж үнэ 100 төгрөг хэвээрээ байгаа, харин хуримтлагдсан алдагдлаас шалтгаалж эздийн өмчийн нийт дүн өмнөх оноос 11,673.1 сая төгрөгөөр буурч, 22,563.3 сая төгрөг болж буурсан.

С.Наранцогт /Хуралдаан даргалагч/: За өөр асуулт байхгүй бол Компанийн 2023 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг аудитын хорооны дарга Б.Чойжил танилцуулна.

Б.Чойжил /Төлөөлөн Удирдах зөвлөлийн аудитын хорооны дарга/: 2024 оны 04 сарын 24-ны өдрийн 14 дугаартай "Багануур" ХК-ийн ТУЗ-ын тогтоол Компанийн тухай хуулийн 76.1.11, 80.2, 96.5 "Багануур" ХК-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.3.1.8 дах заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны санал, дүгнэлтийг тус тус үндэслэн тогтоох нь

"Багануур" ХК-ийн 2023 оны санхүүгийн үйл ажиллагааг "хангалттай" гэж дүгнэсүгэй. "Багануур" ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын байгууллагаас өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирлыг үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/-д даалгасугай.

"Багануур" ХК-ийн 2023 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирлыг үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/-д, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн /Б.Чойжил/-д даалгасугай гэж шийдвэрлэсэн.

С.Наранцогт /Хуралдаан даргалагч/: Энэхүү тогтоолтой холбоотой асуулт байна уу ? байхгүй бол Хоёрдугаар асуудал болох Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлангийн танилцуулгыг "Багануур" ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Түвшинжаргал танилцуулна уу.

Д.Түвшинжаргал /"Багануур" ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч/: 2023 онд манай компанийн голчлон хэрэглэдэг Дизель түлш, тэсрэх материал, туслах материалын үнэ харьцангуй тогтвортой байлаа. Нүүрс олборлолтын хувьд Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанаас 2023 оны 09 сарын 08-ны өдрийн

01/1688 тоот албан бичиг, Эрчим хүчний яамны 2023 оны 10 сарын 02-ны өдрийн 2023/357 тоот албан бичгүүдээр Нийслэлийн 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд тусгай зөвшөөрөл бүхий 60 байршлын 174 халаалтын зууханд 110 мян.тн нүүрс нийлүүлэхийг үүрэг болгосон тул нүүрс борлуулалтын төлөвлөгөөг 125.0 мян.тн-оор нэмэгдүүлсэн. Дээрх нөхцөл байдлыг даван туулахын тулд бид техникуудийн агрегат засварыг оновчтой хүртээмжтэй хийж техникийн бэлэн байдлыг хангах, нүүрсний нөөцийг нэмэгдүүлэхийн тулд хөрс тээврийн оператор компани оруулах зэрэг олон ажлыг хэрэгжүүлэн ажилласан.

ОХУ-ын дотоодын болон дайны нөхцөл байдлаас шалтгаалж үйлдвэрлэсэн дизель түлшийг "Ангарск"-аас татаж эхэлсэн. Үүний нөлөөгөөр 2023 оны 10 сарын эхлэн Монгол Улсад түлшний нийлүүлэлт буурч, 11 сарын 10-наас хойш хомсдол үүсэх хэмжээнд хүрсэн. Багануур ХК-ийн хувьд өөрийн нөөц бололцоог дайчлан 11 сарын 25-ны өдрийг хүртэл түлшний асуудлаа шийдвэрлэж үүнээс цааш УОК-оос тусламж хүссэн. УОК нь Багануур ХК-нд 4 вагон түлшийг буцаан олгох нөхцөлтэйгөөр олгосон.

Мөн манай компанийн 45 жилийн ой энэ жил тохиосон бөгөөд тус ойн хүрээнд Олон улсын эрдэм шинжилгээний хурал, Инженер техникийн ажилтнуудын дундах төслийн уралдаан, Тэрбум мод хөтөлбөр, МСҮТ политехникийн оюутнуудын дунд үр чадварын уралдааныг хэрэгжүүлж, Ажилтнуудыг орон сууцжуулах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхээр бэлтгэж байна. Уурхай ашиглалтад орсноос хойших 45 жилийн хугацаанд нийт 137.0 сая.тн нүүрс олборлож, 509.6 сая.м3 хөрс хуулж, 911.0 сая.м3 уулын цулын ажил хийгээд байна.

Бодлогын чанартай хийсэн ажлууд: Багануур ХК-ийн дунд хугацааны техник эдийн засгийн үндэслэлийг "ROYAL MINING" LLC компанитай хамтран боловсруулж, Эрдэнэс Монгол ХХК-ийн техник технологийн зөвлөл, Багануур ХК-ийн ТУЗ-д танилцуулан УУХҮЯ-ны Ашигт малтмалын газрын Эрдэс Баялагийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулах шатандаа явж байна.

Шинэ техник технологи нэвтрүүлэх, хөрөнгө оруулалт татах зорилгоор "ХБНГУ, Япон улс, Чех улсын элчин сайдын яамнуудтай, Мөн ИТА-ын сургах, судалгаа, төслийн ажлыг хамтран хийх зорилгоор "Монгол Улсын ШУТИС, ХБНГУ-ын GMIT их сургуулиудтай "ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ" байгуулсан.

Нийслэлийн ЗД-ийн нэрэмжит "Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг"-т 93.8% оноотой "ДҮҮРЭН ХАНГАЛТТАЙ" үнэлгээ авсан. Эрдэнэс Монгол Нэгдлийн бүрэлдэхүүн компаниудын ХАБЭА-н ажилчдын дунд "АГААРААС ЭРЭН ХАЙХ, АВРАХ АЖИЛЛАГАА" сургалтыг хийсэн. Улаанбаатар хотод гарсан үерийн гамшиг, цас зудын эрсдэлд орсон ойролцоох сумуудад тусламж үзүүлэх ажлыг зохион байгуулсан.

Багануурын уурхайн нийт ажилчдын 60%-ийг шинэ ажилчид бүрдүүлж байгаа тул "ХҮНДЛЪЕ-СУРАЛЦЪЯ-ХУВААЛЦЪЯ" сэдэвт чиглүүлэх хөтөлбөрийг зохион байгууллаа. Нийгмийн хөгжлийн сангийн журмыг шинэчлэн залуу ажилчдыг орон сууцжуулах хөтөлбөрийг санаачлан ажиллаж байна.

Багануур дүүргийн ЗДТГ-тай байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд дүүргийн төвлөрсөн ХУР ХОГИЙН ЦЭГИЙГ дарж, техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн

2023 онд ЭХЗХ-нд нүүрсний үнэ нэмүүлэх 3 албан бичиг, татаас авах талаар 1 албан бичиг, 2 уулзалтыг ЭХЗХ-той хийсэн. ЭХЯ, УУХҮЯ, ЭМГЛ ХХК-нд нүүрсний үнэ нэмэх, үнийн зөрүүнд төрөөс татаас авах саналыг тус бүр 1 удаа албан бичиг, нотлох баримтын хамт хүргүүлсэн. Гэвч үнэ нэмэх эх үүсвэргүй гэсэн шалтгаанаар үнэ нэмэгдээгүй.

2023 оны 11 сард УБ хотын захирагчийн ажлын алба, ЭХЯ-ны сайд Улаанбаатар хотын жижиг уурын зуухнуудад шигшиж ангилсан нүүрс борлуулахыг үүрэг болгосон. Иймд шигшиж ангилсан нүүрсний үнийг 2023 оны 11 сарын 01-ний өдрөөс 5,488.6 төгрөгөөр нэмэгдүүлж 59,800 төгрөгт хүргэх шийдвэрийг ТУЗ-өөр батлуулан мөрдөн ажиллаж байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль"-иар хориглосон аливаа орлого, зардал гаргалгүй хуулийг бүрэн хэрэгжүүлж ажилласан. Компани дотооддоо хэмнэлтийн төлөвлөгөө гарган 3,018.4 сая төгрөгийг үйл ажиллагааны зардлаас хэмнэж ажилласан.

2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажилд шаардлагатай санхүүжилтийг ЭТТ ХК-ийн өмнөх оны үлдэгдэл зээл болох 6.6 тэрбум төгрөгөөр шийдвэрлэсэн. Ажилчдын цалинг Багануур дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг 4 банктай 4.6 тэрбум төгрөгийн цалингийн шугамын зээлийн гэрээ байгуулан ажилласан.

2020 оны 1-р сарын 1-ны өдрөөс хойш ажилчдын цалинг нэмээгүй байсныг ЭМГЛ ХХК, ТУЗ-д танилцуулан 2023 оны 01-р сарын 01-ны өдрөөс 20%, 2023 оны 11-р сарын 01-ны өдрөөс дахин 10% нэмэгдүүлсэн. Цалингийн сүлжил: 18 жилийн өмнөөс мөрдөж байсан цалингийн сүлжлийг шинэчлэн, 4 сүлжилд хувааснаар түлхүүр ажлын байрны цалинг нэмэх боломж бүрдсэн.

2023 онд батлагдсан нийт зорилтот түвшний 17 үзүүлэлтээс 10 зорилт 100%, 5 зорилт 95%, 1 зорилт нь 56.2%, 1 зорилт хангагдаагүй нийт дүнгээр 96.8%-ийн гүйцэтгэлтэй ажилласан байна. Төслийн хүчин чадал 4.0 сая.тн бөгөөд 2023 онд хүчин чадлыг 116 хувь буюу 648.4 мян.тн-оор давуулан ажилласан.

2023 онд нүүрс олборлолт 4,648.4 мян.тн, нүүрс борлуулалт 4,628.1 мян.тн, Хөрс хуулалт 17,866.7 мян.м3, Шидэлт 3,201.1 мян.м3, Инженерийн ажил 894,5 мян.м3 ажлыг тус тус хийсэн байна. Мөн авлага өмнөх оноос буурч 8.2 тэрбум.төг болсон. Өр төлбөрийн хувьд богино хугацаат өр төлбөрийн хувьд 130.4 тэрбум төгрөг болж буурч, урт хугацаат өр төлбөр 112.5 тэрбум төгрөг болж нэмэгдсэн.

2023 онд худалдан авах ажиллагааны хувьд нийт 156 тендер шалгаруулалт зарлаж 124 нь амжилттай болж 79.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Компани 2023 онд төлөвлөсөн алдагдлыг 249.1 сая төгрөгөөр бууруулж ажилласан ч жилийн эцсийн дүнгээр 9,516.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь цаашид нүүрсний ҮНИЙГ нэмэгдүүлэх, эсвэл үнийн зөрүүний алдагдлыг төрөөс ТАТААС хэлбэрээр авах зайлшгүй шаардлагатайг харуулж байна.

Компани 2023 онд суурилагдсан хүчин чадлаа 15%-иар давуулж 4,628 мян.тн нүүрс олборлон борлуулсан. 2024 онд 4,734 мян.тн нүүрс нийлүүлэх захиалга авсан ч хэрэглээ нэмэгдэж 4,907 мян.тн хүрэхээр байна. Иймд уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх, нэн түрүүнд ТЕХНОЛОГИ ДАМЖЛАГА-3-ийг шинээр барих санхүүгийн эх үүсвэрийг яаралтай олох шаардлага үүсэж байна.

Нийт ажилтнуудын 50%-ийг компанид 10 хүртэлх жил ажилласан залуучууд эзэлж байгаа учраас залуу ажилчдыг ОРОН СУУЦЖУУЛАХ, УР ЧАДВАРЖУУЛАХ ХӨДӨЛБӨР гаргах шаардлагыг үүсгэж байна.

Компанийн өр төлбөр 242.9 тэрбум төгрөгт хүрснээр өр, авлагын харьцаа 30/1, мөн жилийн борлуулалтын орлогоос 1.15 дахин илүү болсон нь компанийг дампуурлын түвшинд аль хэдийн очсоныг харуулж байна. Үүнээс болж БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭГЧ КОМПАНИ, ТАТВАРЫН БАЙГУУЛЛАГА шүүхээр алданги торгууль тавих байдал нэмэгдэж компанийн санхүүг улам хүнд байдалд оруулж байна.

Дэлхийн улс орнууд ногоон, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлд гол анхаарлаа хандуулж байгаа ч сүүлийн жилүүдэд их гүрнүүдийн ГЕО УЛС ТӨРИЙН зөрчилдөөн хурц байдлаар илрэх боллоо. Энэ тогтворгүй үед МУ-ын эрчим хүчний салбар ойрын 10 жилд уламжлалт нүүрсний цахилгаан станцуудаа түшиглэх, тэдгээрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх бодлого тодорхойлох нь оновчтой гэж үзэж байна.

Асуулт: О.Эрдэнэбилэг /Хувьцаа эзэмшигч/: Хөрс хуулалтын оператор компани оруулсан гэсэн байна. 1м3 хөрс хуулалтын тээврийг хэдээр хийлгэсэн бэ ?

Хариулт: Г.Нацагдорж "Багануур" ХК-ийн ахлагч эдийн засагч: 425,000 м3 хөрс хуулалтыг 1.5 тэрбум төгрөгийн өртөгтэйгөөр буюу 1 м3 хөрсийг 1,295.8 төгрөгөөр тээвэрлэсэн. Энэ нь манай өртгөөс 3-4 хувь доошоо өртөг байгаа.

Асуулт: О.Эрдэнэбилэг /Хувьцаа эзэмшигч/: Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зардал, нийгэм соёлын зардал чинь хэд болсон вэ ?

Хариулт: Д.Даваадаш /"Багануур" ХК-ийн Хүний хөгжил судалгаа эрхэлсэн дэд захирал /: Компанийн хэмжээнд 2023 онд нийтдээ 222 тэрбум төгрөгийн зардал гаргасан үүнээс нийгэм соёлын арга хэмжээний зардал 3.6 тэрбум төгрөгийн зардал гаргасан энэ нь үйлдвэрчний эвлэлтэй байгуулсан хамтын гэрээний дагуу гардаг зардал байдаг бөгөөд нийт зардлын 1.6 хувийг бүрдүүлж байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зардалд 2.6 тэрбум төгрөгийг зарцуулсан энэ нь нийт зардлын 1.2 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд эрүүл мэндийн даатгалын зардлыг оруулаад хуульд заасан 4 хувьд хүрч байгаа.

Асуулт: О.Эрдэнэбилэг /Хувьцаа эзэмшигч/: 2023 онд компани дээр үйлдвэрийн осол гарсан байна. Компанийн гол баримтлах зарчим чинь өөрөө осол авааргүй байх шүү дээ. Толгой компани, хувьцаа эзэмшигчээс ямар тусламж үзүүлсэн вэ?

Хариулт: Д.Түвшинжаргал /"Багануур" ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч/: Компани хэдий алдагдалтай ажилладаг ч гэсэн Хөдөлмөрийн аюулгүй байдлын олон улсын стандартыг нэвтрүүлж ажилладаг. Үйлдвэрийн осол гарсан даруйд холбогдох бүх байгууллагад мэдэгдэж танилцуулсан. Төлөөлөн удирдах зөвлөл, Эрдэнэс Монгол нэгдлээс дахиж ийм осол аваар гаргахгүй байх үүднээс гүйцэтгэх удирдлагад тэмдэглэлээр тодорхой үүрэг даалгавар өгсөн. Үүнийх нь дагуу энэ оноос хяналтын цогц систем нэвтрүүлж байгаа бөгөөд тендер сонгон шалгаруулалт явагдаж байгаа. Энэ явцаараа 9 сарын 15 гэхэд энэ ажлаа дуусгахаар жигдрүүлэн ажиллаж байгаа.

Асуулт: Д.Алтансүх /Хувьцаа эзэмшигч/: Татварын өр төлбөр дээр тэр доор алданги гээд 7.6 тэрбум гэсэн байгаа нь энэ жилийн төлөлт үү ?

Хариулт: Д.Түвшинжаргал /"Багануур" ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч/: Энэ бол миний өмнө ярьсан шүүх дээр маргаантай явж байгаад он гараад Улсын дээд шүүхээс буцаасан асуудал байгаа.

Асуулт: Д.Алтансүх /Хувьцаа эзэмшигч/: Аж ахуй нэгжийн орлогын албан татвар 1.3 тэрбум төгрөг гэж байна. Энэ хэдэн оны татварын өглөг гараад ирэв ?

Хариулт: Б.Наранбаатар /Багануур ХК-ийн Ерөнхий нягтлан бодогч/: 2021 онд санхүүгийн тайлангаараа 2 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан бөгөөд үүнээс татварын өглөг нь 1.3 тэрбум болж үүссэн баланс дээрх төлбөр байгаа.

Асуулт: Ж.Энхтунгалаг /Хувьцаа эзэмшигч/: Үрээр мод тарьж байгаа гэсэн байна. Үр дээр хэдэн төгрөгийн зардал гарч байгаа вэ ? Худалдаж авч байгаа юу ?

Хариулт: Д.Түвшинжаргал /"Багануур" ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч/: Үрээ бид шууд ойгоос бэлтгэж байгаа бөгөөд худалдаж авахгүй байгаа зөвхөн түүнийг бэлтгэх шатахуун тос, хоол, томилолтын зардал гарч байгаа.

С.Наранцогт /Хуралдаан даргалагч/: За өөр асуулт байхгүй бол Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг аудитын хорооны дарга Б.Чойжил танилцуулна.

Б.Чойжил /Төлөөлөн Удирдах зөвлөлийн аудитын хорооны дарга/: Компанийн тухай хуулийн 76.1.11, 80.2 "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 97 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан "Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам"-ын 5.1, 5.4 дэх заалт, "Багануур" ХК-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.3.1.8 дах заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ: 1."Багануур" ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны тайланг "ХАНГАЛТТАЙ" гэж дүгнэсүгэй. 2.Багануур ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтийг хавсралтаар баталсугай. 3.Багануур ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны тайланг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/-д, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн /Б.Чойжил/-д даалгаж шийдвэрлэсэн.

С.Наранцогт /Хуралдаан даргалагч/: Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлттэй холбоотой асуух асуулттай хүн байна уу? За байхгүй бол хэлэлцэх асуудлын гуравдугаар асуудал болох ногдол ашиг хуваарилах эсэх талаар гарсан Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ч.Дондогмаа уншиж танилцуулна.

Ч.Дондогмаа /Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга/: Багануур ХК-ийн 2024 оны 02 сарын 19-ны өдрийн 03 дугаартай ногдол ашиг хуваарилах эсэх тогтоолыг уншиж танилцуулав.

С.Наранцогт /Хуралдаан даргалагч/: Ногдол ашиг хуваарилах тухай тогтоолтой холбоотой асуух асуулт байна уу? байхгүй бол хэлэлцэх асуудлын дөрөвдүгээр асуудал болох Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Компанийн хүний хөгжил судалгаа эрхэлсэн дэд захирал Д.Даваадаш танилцуулна.

Д.Даваадаш /"Багануур" ХК-ийн Хүний хөгжил судалгаа эрхэлсэн дэд захирал /: Багануур ХК-ийн дүрмийг 2023 оны 04 дүгээр 27-ны өдрийн ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн баталсан байдаг. Дүрэм нь 6 бүлэг 67 заалттай байна. Дүрэмд дараах 3 заалт дээр нэмэлт өөрчлөлт орж байгаа. Дүрмийн 3.3.1 дэх хэсэгт "Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөлт цагт компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байна. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ." Гэсэн заалтын 3.3.1.9 дэх хэсэг дээр компанийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох, данснаас хасах гэсэн заалт нэмэлтээр орж байна. Дараагийн өөрчлөлт орж буй заалт бол 3.3.8 дах заалт бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг компанийн тухай хуулийн 77.5-д зааснаас гадна толгой компаниас баталсан холбогдох журамд заасан нөхцөлөөр дуусгавар болгож, чөлөөлж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль хүртэл Төлөөлөн удирдах зөвлөл түр томилж болно; гэсэн заалтын сүүлийн өгүүлбэрийг хасаж тус заалтын 3.3.9 дэх хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа гурав хүртэлх жилээр томилж болох бөгөөд ажлын гүйцэтгэл, үйл ажиллагааны тайланг үнэлж нэг удаа улируулан томилж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль хүртэл Төлөөлөн удирдах зөвлөлөөс түр томилж болно." Гэж нэмэлтээр орж байна.

С.Наранцогт /Хуралдаан даргалагч/: Танилцуулгатай холбоотой асуулт асуух гишүүн байна уу?

Асуулт: О.Эрдэнэбилэг /Хувьцаа эзэмшигч/: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд яг хэд хэдийн харьцаатай 3 жилээр сонгоно гэсэн байна. өөрсдийгөө шагнаад дахин сонгогдоод явах юм уу?

Хариулт: Даваадаш /"Багануур" ХК-ийн Хүний хөгжил судалгаа эрхэлсэн дэд захирал /: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоонд өөрчлөлт орохгүй, компанийн тухай хуульд заасан сонгох зарчмын дагуу сонгогдоод явна.

Асуулт: О.Эрдэнэбилэг /Хувьцаа эзэмшигч/: Өмнөх хурал дээр ч хэлсэн наад хувийн төлөөлөлдөө хоёрхон эрх олгочхоод төр өөрсдөө 12 хүнээ аваад байхаар чинь энэ төрийн заваарсан тогтолцоо арилахгүй шахааны компани гэж хэлэгдээд байна шүү дээ хувийн төлөөлөл чинь 25 хувь эзэмшиж байхад 2 хүн гэдэг чинь харьцангуй байна.

Хариулт: Даваадаш /"Багануур" ХК-ийн Хүний хөгжил судалгаа эрхэлсэн дэд захирал /: Компанийн тухай хуульд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 3 хуваасны 1 нь хараат бус гишүүн байхаар заасан бөгөөд өнөөдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 12 гишүүний 4 нь хараат бус гишүүн үлдсэн 8 гишүүний эрхийг нэгж хувьцаанд нь ногдох хэмжээнд хувааж хувийн эзэмшлийн 2 гишүүний эрхийг Монголиан нейшнл коүл корперэшн ХХК-д олгож 6 гишүүн нь төрийн мэдлийн хувьцааны эрхийг хэрэгжүүлэхээр сонгогдож байгаа. Компанийн тухай хуульд заасны дагуу бүхий үйл ажиллагаа явагдаж байгаа.

С.Наранцогт /Хуралдаан даргалагч/: За өөр асуулт байхгүй бол дараагийн асуудал буюу хэлэлцэх асуудлын тав дах асуудал буюу Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийн сонгох асуудлын талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нэр дэвшүүлэх хорооны гишүүн Б.Мөнхзаяа танилцуулна.

Б.Мөнхзаяа /Төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшүүлэх хорооны гишүүн/: "Багануур" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны хуралд хорооны дарга Б.Гэрлээ, гишүүн Б.Чойжил, Б.Мөнхзаяа нар оролцов. "Багануур" ХК-ийн компанийн ердийн болон хараат бус гишүүдийг нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцэв. Тус асуудалтай холбогдуулан дараах дүгнэлтийг гаргав:

1.Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл "Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх", 62.1. дэх хэсэг "Дараах асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ:", 62.1.7 дах заалт "төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох:", 77.1 дэх хэсэг "77.1.Энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгоно" 81.5.3. дэх хэсэг "төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх", Багануур ХК-ийн дүрмийн 3.3.2 дах заалт "Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь 12 гишүүнтэй байх бөгөөд үүний 1/3-ээс доошгүй нь хараат бус гишүүн байна", Багануур ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны журмын 2.1.3. "ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх" гэж тус тус заасны дагуу Ердийн гишүүнээр Ч.Дондогмаа, Б.Гэрлээ, И.Лувсанцэрэн, Д.Эрдэнэбаяр, М.Мэндбаяр, Д.Санчир, М.Отгонбаяр, Д.Чинбат Хараат бус гишүүнээр Ц.Болдбаатар, Ө.Гэрэлт-Од, Б.Чойжил, Б.Мөнхзаяа нарыг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр нэр дэвшүүлэх саналтай байна.

С.Наранцогт /Хуралдаан даргалагч/: Энэ асуудалтай холбоотой асуулт байна уу ?

Асуулт: М.Отгонбаяр Хувьцаа эзэмшигч /Монголиан нейшнл коүл корпорейшн ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч/: Хувьцаа эзэмшигчдийн хурал бол компанийн эрх барих дээд байгууллага, Өмнөх оны хувьцаа эзэмшигчдийн хурал дээр манай компанийн зүгээс 2 санал тавьсан Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоог 12

биш 9 болгоё гэж, Мөн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн илүү мэргэжлийн хүмүүсээр томилох шаардлагатай байна. Энэ Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд мэргэжлийн хүн ганц хоёрхон байна. Илүү уул уурхай, техникийн хүмүүсийг оруулж ирэх хэрэгтэй байна. Энэ саналыг Эрдэнэс Монгол компанийн зүгээс авч хэлэлцэхгүй юм уу ?

С.Наранцогт /Хуралдаан даргалагч/: Энэ асуултад би хариулчихъя, Эрдэнэс Монгол нэгдлийн хэмжээнд ер нь энэ засгийн газрыг түвшинд ямар ажлууд хийгдсэн цаашид ямар ажил хийгдэх талаар би хаалтын үг дээр ярина. Одоо тодорхой хэсгийг нь хэлчихье. Энэ жил Эрдэнэс Монгол нэгдлийн хэмжээнд мөн манай Багануур ХК-ийн хувьд ч ялгаагүй түүхэн амжилт гаргасан жил байлаа. Мөн дунд хугацааны стратеги төлөвлөгөө батлагдсан үүнтэй холбоотой санал гомдлуудыг хүлээн авч ойлгож шийдвэрлэсэн. Өнгөрсөн жилүүдэд сайн ажилласан цаашид дараах жилүүдийг хэрэгжилт үр дүнгийн жил болгон тогтоож ажиллах болно. Сая баталсан баялгийн сангийн хуулиар Төрийн өмчийн уул уурхайн компанийн удирдлага болон төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц болон бусад зүйлсийг бусад төрийн өмчийн компани буюу зам засварын зэрэг бусад компаниас өөрөөр тогтоож өгөх талаар тусгасан. Засгийн газар ер нь энэ уул уурхайн компаниудаа тусад нь илүү нарийн шаардлагын дагуу дүгнэдэг болж байгаа. Энэ хүрээнд боломжийн сайн ажилласан удирдлагын баг буюу өнөөдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн үргэлжлүүлэн ажиллуулах саналтай байгаа. Ер нь энэ Баялгийн сангийн хуулийн гол зүйлийг та бүхэнд танилцуулбал, энэ уул уурхайн компаниуд ашигтай ажиллах ногдол ашгийн зайлшгүй хуваарилах хамгийн том агуулга тусгагдсан. Энэ хуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын төлөвлөгөөг мөн батлахаар ажиллаж байна. Иймд энэ жилийн хувьд төрийн өмчийн бүх компанийн хувьд удирдлага, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд өөрчлөгдөхгүйгээр орж ирж байгаа.

Асуулт: М.Отгонбаяр Хувьцаа эзэмшигч /Монголиан нейшнл коул корпорейшн ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч/: Энэ асуудлыг ярьж байгаа үндсэн шалтгаан маань манай хараат бус гишүүд сайн ажилласан. Гэвч төрийн төлөөллийн гишүүд хангалтгүй ажилласан буюу төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаа оролцдоггүй маш идэвхгүй оролцсон. Өмнөх хувьцаа эзэмшигчдийн хурлаар Төлөөлөн удирдах зөвлөл томилогдоод 2, 3 сар хуралдаагүй тэр хугацаанд дарга ч үгүй явж ирсэн. Сүүлд Ч.Дондогмаа дарга томилогдоод хурал явагдаж эхэлсэн. Мөн асуудал шийдье гэхээр төрийн төлөөллийн удирдамж нь гарч ирдэггүй бүтэн сар хойшлох тохиолдол байдаг. Төрийн төлөөлөл бол хариуцлагагүй хандаж байгаа. Одоо Багануур ХК-ийн агуулахын үлдэгдэл 44 тэрбум төгрөг байна. энэ агуулахыг үлдэгдлийг ялгаж ангилж ашиглахыг нь ашиглаж ашиглахгүйг нь худалдан борлуулах, устгах ажиллагааг зохион байгуулах зайлшгүй шаардлагатай байна. Төлөөлөн удирдах зөвлөл бол хурдан шуурхай ажиллах шаардлагатай тул тооны асуудлыг дахин авч үзэх шаардлагатай.

Ч.Дондогмаа /Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга/: Өнгөрсөн хувьцаа эзэмшигчдийн хурлаас манай Төлөөлөн удирдах зөвлөл томилогдсон. Анхны хурлаа өнгөрсөн 6 сард хийж Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон хороодын гишүүдээ томилсон. Төрийн төлөөлөл хэрэгжүүлэгчдийн хувьд идэвх оролцоо сул

байдаг нь үнэн бөгөөд мэргэжлийн яамнуудын голлох мэргэжилтнүүд буюу дандаа газрын дарга нар оролцсон байгаа. Бид аль болох Төлөөлөн удирдах зөвлөлийн ирцийг бүрдүүлэх зүгээс цахим болон танхимын хосолсон аргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаа зохион байгуулдаг.

Б.Гэрлээ /Эрдэнэс Монгол ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн эрх хэрэгжүүлэгч/: Мөн эрчим хүчний яамнаас түлшний бодлогын газрын дарга, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас бодлогын газрын дарга, Эдийн засаг хөгжлийн яамнаас аж үйлдвэрийн бодлогын газрын дарга, манай хоёр хувийн төлөөлөл ч мөн салбарын мэргэжлийн хүмүүс байгаа. Мөн засаглалын сайн зарчим, эрх бүхий албан тушаалтнуудын залгамж халааг хангах хүээнд мэргэжлийн хүмүүстэйгээ ажлын уялдаагаа хангаад ажилласан нь зүйтэй гэж дүгнэсэн байгаа.

С.Наранцогт /Хуралдаан даргалагч/: Энэ удирдамж удсан болон ирц идэвхийн асуудалтай би биечилж танилцаад холбогдох яам агентлаг газрууд руу нь албан ёсны байдлаар хандах нь зүйтэй. Энэ хүмүүс чинь бас хариуцлагатай чухал ажил хийж байгаа хүмүүс хаана хаанаа алдаа дутагдлаа залруулаад ажиллах нь зүйтэй. Мөн хараат бус гишүүдийн тоог нэмэх ажлууд хийгдээд явж байгаа. Иймд та бүхний хэлж байгаа зүйлсийг бид анзаараад олон улсын стандарт журамд нийцсэн байдлаар ажиллаж байгаа.

Асуулт: О.Эрдэнэбилэг /Хувьцаа эзэмшигч/: Энэ компанийн дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт чинь хууль зөрчсөн зүйл байгаа юу судалгаа хийсэн үү ? энэ өөрчлөлт орсноороо хэт толгой компаниасаа хараат болох эрсдэлтэй байна энэ талаар судалсан уу ?

Б.Гэрлээ /Эрдэнэс Монгол ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн эрх хэрэгжүүлэгч/: Хууль журамд бүрэн нийцэж байгаа.

С.Наранцогт /Хуралдаан даргалагч/: Хурлын дэгийн дагуу хурлын үйл ажиллагаа 20 минут завсарлана. Энэ хугацаанд хувьцаа эзэмшигчид саналын хуудсаар саналаа гарган Тооллогын комисст өгөв.

С.Наранцогт /Хуралдаан даргалагч/: Саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар авсан санал хураалтын дүнг Тооллогын комиссын дарга Б.Хажидмаа танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Б.Хажидмаа:

“Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоол, 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 02.

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчээс 20,148,249 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчид оролцож 7 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна. Хүчингүй саналын хуудас байхгүй, санал өгөөгүй 1

Санал өгсөн байдлыг үзвэл

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай.

Зөвшөөрсөн	20,148,244.00	санал 100% хувь
Татгалзсан	-	санал 0.0% хувь
Түдгэлзсэн	-	санал 0.0% хувь

"Багануур" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоол, 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 03.

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчээс 20,148,249 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчид оролцож 7 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна. Хүчингүй саналын хуудас байхгүй, санал өгөөгүй 1

Санал өгсөн байдлыг үзвэл

2. Компанийн 2023 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай.

Зөвшөөрсөн	20,148,249.00	санал 100% хувь
Татгалзсан	-	санал 0.0% хувь
Түдгэлзсэн	-	санал 0.0% хувь

"Багануур" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоол, 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 04.

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчээс 20,148,249 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчид оролцож 7 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна. Хүчингүй саналын хуудас байхгүй, санал өгөөгүй 1

Санал өгсөн байдлыг үзвэл

3. Ноогдол ашиг хуваарилах эсэх талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн танилцуулга

Зөвшөөрсөн	20,148,133.00	санал 99.999% хувь
Татгалзсан	-	санал 0.0% хувь
Түдгэлзсэн	11.00	санал 0.001% хувь

"Багануур" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоол, 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 05.

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчээс 20,148,249 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчид оролцож 7 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна. Хүчингүй саналын хуудас байхгүй, санал өгөөгүй 1

Санал өгсөн байдлыг үзвэл

4. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Зөвшөөрсөн	20,148,133.00 санал 99.999% хувь
Татгалзсан	- санал 0.0% хувь
Түдгэлзсэн	111.00 санал 0.001% хувь

“Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоол, 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 06.

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг хувьцаа бүхий 251,692,320 саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдээс 20,148,232 ширхэг хувьцаа бүхий 241,778,784 саналын эрхтэй хувьцаа эзэмшигч оролцож ТУЗ-ын гишүүдийг сонгох кумулятив аргаар нийт саналын эрхийн 66.7%-иар ердийн гишүүдийг сонгох санал хураалт явуулж 6 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна.

Хүчингүй саналын хуудас байхгүй, санал өгөөгүй 2

Санал өгсөн байдлыг үзвэл

- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах нэр бүхий ердийн гишүүдийг сонгосонд тооцсугай. Санал хураалтын дүн:

Б.Гэрлээ	20,148,232.0	санал
Ч.Дондогмаа	20,148,232.0	санал
И.Лувсанцэрэн	20,148,232.0	санал
Д.Эрдэнэбаяр	20,148,232.0	санал
М.Мэндбаяр	20,148,232.0	санал
Д.Санчир	20,148,232.0	санал
М.Отгонбаяр	20,148,232.0	санал
Д.Чинбат	20,148,232.0	санал

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг хувьцаа бүхий 251,692,320 саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдээс 20,148,232 ширхэг хувьцаа бүхий 241,778,784 саналын эрхтэй хувьцаа эзэмшигч оролцож ТУЗ-ын гишүүдийг сонгох кумулятив аргаар нийт саналын эрхийн 33.3%-иар хараат бус гишүүдийг сонгох санал хураалт явуулж 6 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна.

Хүчингүй саналын хуудас байхгүй, санал өгөөгүй 2

Санал өгсөн байдлыг үзвэл:

- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах нэр бүхий хараат бус гишүүдийг сонгосонд тооцсугай. Санал хураалтын дүн:

Ц.Болдбаатар	20,148,232.0	санал
Ө.Гэрэлт-Од	20,148,232.0	санал
Б.Чойжил	20,148,232.0	санал
Б.Мөнхзаяа	20,148,232.0	санал

С.Наранцогт /Хуралдаан даргалагч/: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг сая сонслоо, тус комиссын тогтоолд үндэслэн дараах тогтоолууд гарч байна.

1. Компанийн 2023 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай;
2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай;
3. "Багануур" ХК-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай.

За би энэхүү хувьцаа эзэмшигчдийн хурлын хаалт болгон хэд хэдэн зүйлсийг тэмдэглэж хэлье.

Монгол Улсын Засгийн газраас стратегийн ач холбогдол бүхий орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулах, үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор олон ажлуудыг зохион байгуулж ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд 2007 онд "Эрдэнэс Монгол" ХХК-ийг үүсгэн байгуулж, ажиллуулж нэгдлийн анхны бүрэлдэхүүн компани болж "Багануур" ХК ажиллаж байсан түүхтэй. Өнгөрсөн жил Монгол Улсын эдийн засаг тэр дундаа валютын нөөц суларч, зах зээл дээр сая төгрөгөөс илүүгүй хэмжээгээр ам.долларыг худалдахгүй байсан хүнд нөхцөл байдал байсан. Энэхүү нөхцөл байдал нь төрийн өмчийн компаниудын үйл ажиллагааны доголдлоос үүссэн гэж үзэж Монгол Улсын Засгийн газраас 362 дугаар тогтоолыг гаргаж цогц арга хэмжээ авсан. Үүний нэг хэсэг нь төрийн өмчийн компани ялангуяа экспортын чиглэлээр ажилладаг компаниудын валютыг төвлөрүүлэх, сайжруулах үйл ажиллагааг эхлүүлсэн. Энэ хүрээнд Эрдэнэс Монгол ХХК-ийн бүрэлдэхүүнд үйл ажиллагаа явуулж буй компаниудын засаглал үйл ажиллагааг сайжруулах, өөрчлөлт шинэчлэлтийг зарлаж хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү ажлын үр дүнд Монгол улсын валютын нөөц хангалттай түвшинд хүрсэн. Эдийн засаг эрчимжиж байгаатай холбогдон эрчим хүчний хэрэгцээ шаардлага нэмэгдэж түүнийг үйлдвэрлэгч түүхий эд болох эрчим хүчний нүүрсний хэрэгцээний 60 хувийг дангаар нуруун дээрээ үүрч яваа "Багануур" ХК-ийн үйл ажиллагааг хэлэх шаардлагатай. Мөн "Багануур" ХК-ийн 45 жилийн ойн хүрээнд Нүүрс гаралтын төлөвлөгөөг 105 хувь, Борлуулалтын төлөвлөгөөг 100.1 хувь, хөрс хуулалтын төлөвлөгөөг 102.1 хувь, нийт уулын цулын төлөвлөгөөг 100.3 хувиар давуулан биелүүлж, 4,638.4 мян.тн нүүрс борлуулж эрчим хүчний салбар болон Монголын ард түмний өмнө хүлээсэн үүргээ нэр төртэйгөөр биелүүлсэн гэдгийг цохон тэмдэглэж байна. Үүнээс гадна "Багануур" ХК-ийн санхүүгийн сахилга батын сайжруулан, бэлтгэн нийлүүлэлтийн өр төлбөрийг багасгаж, 12 жилийн хугацаанд хуримтлагдсан нийгмийн даатгалын өр төлбөрийг барагдуулсныг мөн цохон тэмдэглэж байна. Нэгдлийн хувьд мөн компани хоорондын өр төлбөрийн шийдвэрлэж "Багануур" ХК-ийн 30 тэрбум төгрөгийн өрийг шийдвэрлэх ажлыг хэрэгжүүлж ажиллаж байна. Мөн Нэгдлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулж баталсан бөгөөд охин компани болон хувьцаа эзэмшигч нар маань сайн судалж шийдвэртэй тусгах шаардлагатай. Багануурт үндсэн 6 байршилд аж үйлдвэрлэлийн паркийн чиглэлээр төсөл хэрэгжүүлэх, энэхүү аж үйлдвэрийн паркийг дагасан хувийн аж ахуй нэгжүүдийн хөрөнгө оруулалтыг

дэмжих, боловсруулах үйлдвэрийг байгуулах, дэд бүтэц үндсэн түүхий эдийг нэгдлийн хэмжээний компаниуд үйлдвэрлэх төлөвлөгөө гарсан. Паркуудын ерөнхий төлөвлөгөө хийгдэж байна. Мөн эрчим хүчний үнийг хатуу тогтоосон тогтолцоог өөрчлөх асуудлыг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн зүгээс тодорхой байр суурийг илэрхийлж үнийг чөлөөлөх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах болно. Мөн үүн дээр нэмэгдэж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх аж үйлдвэрийн паркийн асуудлын шийдвэрлэхээр ажиллаж байна. Энэ бүгдийг бүтээх бий болгох гол хөшүүрэг болох хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр Баялгийн сангийн тухай хууль болон бусад хууль журмын дагуу шинэчлэн сайжруулж, компанийн засаглал, санхүүгийн сахилга бат сайжирна гэж үзэж байна. Үүний үр дүнд компаниуд ашигтай ажиллаж иргэд хувьцаа эзэмшигч нарт ногдол ашиг хуваарилах боломж бүрдэх бөгөөд тодорхой хувийг нэгдлийн хэмжээний бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх боломж бололцоо бүрдэж байна. Иймд бид 2024 онд хэрэгжилт үр дүнгийн жил болгож ажиллаж 2028 он хүртэл стратеги төлөвлөгөөний дагуу ажиллаж чадвал манай нэгдэл болон бүрэлдэхүүний компаниудын үйл ажиллагаа дараагийн түвшинд хүрэх боломжтой.

2024 оны ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурал амжилттай хуралдаж дууслаа. Идэвхтэй оролцсон хувьцаа эзэмшигч нартаа баярлалаа. Хурал хаасныг мэдэгдье.

Хурал 14:13 цагт дуусав.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ



С.НАРАНЦОГТ

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга

Б.Жавхлан